

**ГХБХБГ-ЫН 05 ДУГААР САРЫН 1 ДЭХ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2016.05.05.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Улаанбаатар хотод 2017 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд Барилга, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд манай байгууллагаас Газрын дарга, БХБХэлтсийн дарга, мэргэжилтнүүд оролцов.</p> <p>Баян-Өлгий Аймгийн Хөгжимт Драмын Театрт Онцгой байдлын газрын "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль" 2017 оны 05 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд зохион байгуулагдах сургалт, дадлагын хуралд манай байгууллагын Гамшгаас хамгаалах барилга хот байгуулалтын албаны бие бүрэлдэхүүнээрээ оролцлоо.</p> <p>“ТИРЛИК” захын урьд талын зам дагуу зөвшөөрөлгүй дур мэдэн нийтийн эдэлбэр, төрийн өмчийн газарт худалдааны цех барьж түрээслүүлэн хууль бусаар ашиг олж байгаа Иргэд Л.Тогай, Б.Бекжан, Х.Айланыш, Н.Бейбитхан нар болон мөн хууль бусаар “ДАРМЕК” эмийн сан ажиллуулан ашиг олж байгаа Х.Серикгүл нарт аймгийн МХГазрын байгаль орчин, газар, геодези зураг, зүйн хяналтын улсын байцаагч Б.Жандаурентэй хамт хяналт шалгалт хийж зарим зөрчлүүдийг арилгуулав.</p> <p>Берик 4 ХХК зочид буудал, үйлчилгээний барилгын суурийн зуурмагаас конусан суултыг, иргэн Танайгийн 32 айлын орон сууц, Муратбекийн 16 айлын орон сууц, үйлчилгээний барилгын хучилтын зуурмагаас газар дээр нь конусан суултын шинжилгээг хийсэн болно.</p> <p>Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг буруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж,шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах ажлаар хийгдсэн мэдээллийн сан, программ хангамжийн хэрэглээний мэдлэг, дадлага олгох сургалтад байгууллагын 3 мэргэжилтэн 2017 оны 4-р сарын 25-27-ний өдрүүдэд Барилгын хөгжлийн төвд хамрагдав.</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР